



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД Л.ЭНХ-АМГАЛАН  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-18, Факс: 32-70-16  
E-mail: stategreatkhural@parliament.mn  
http://www.parliament.mn

2022.12.24 № 57

Сургуулийн орчинд үйлдэгддэг  
зарим гэмт хэргийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. Дэлхий дахинд нийт сурагчдын 30 хувь нь сургуулийн орчинд дээрэлхүүлснээс үүдэн сурлагын амжилт нь буурч, сургууль завсардаж, мөн бие бялдар, сэтгэцийн эрүүл мэндээр хохирсон гэсэн судалгаа байна.

ЮНЕСКО-гоос эрхлэн хэвлүүлсэн "Тоо, баримтын цаана: Сургуулийн орчин дахь дээрэнгүйлэл, хүчирхийллийг зогсоох нь" тайланд дурдсанаар Монгол Улсын хувьд сүүлийн 12 сарын хугацаанд сургуулийн орчинд дээрэлхүүлсэн, хүчирхийлэлд өртсөн сурагчдын ихэнх нь 14 настай хүүхдүүд байсан бөгөөд, 43.8 хувь нь зодоон хийсэн бол 30 хувь нь бие махбодын халдлагад өртсөн байна.


Тиймээс 2010-2022 оны хооронд сургуулийн орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг, тодруулбал үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, сургуулийн орчинд үйлдэгдсэн бусад гэмт хэрэг болох тэдгээрийн тоон мэдээлэл,

2. Тэдгээр гэмт хэргүүдийг шийдвэрлэсэн байдал, үүнээс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид уг асуудлыг бууруулахад хууль эрх зүйн орчинд ямар шинэчлэл хийх гэж буй талаарх мэдээлэл, судалгаа зэрэг болно.

Дээрх асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлж, Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

С.ОДОНТУЯА



2022000069